



“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК

ХУРЛЫН ШИРЭЭ, САНДАЛ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Харьцуулалт
гэрээний нэр, дугаар: **ТТТЗ/201909044**

Улаанбаатар хот
2019 он

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо : **2019-11-22**

Тавантолгой төмөр зам ХХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **хурлын ширээ, сандал**–ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2019 оны 12 сарын 02-ны өдрийн 14 цаг 00 минутаас өмнө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2019 оны 12 сарын 02-ны өдрийн 14 цаг 30 минутад нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Юнион бюлдинг
В блок, 11-р давхар, “Тавантолгой төмөр зам” ХХК.
Имэйл хаяг: info@ttz.mn
Утас: +976-77777727

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.

- | | |
|--|---|
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан ирүүлэх</p> <p>Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 оны аль нэг жилд хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, хүлээлцсэн актын хамт/;</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын танилцуулга 2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 3. Татварын газрын цахим тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар ирүүлэх/ 4. НӨАТ төлөгчийн гэрчилгээний хуулбар 5. Тавантолгой төмөр зам” ХХК-ийн зүгээс тендерт оролцогчийн харилцагч банк, харьяа татварын алба, шүүх болон бусад байгууллагаас лавлагаа, тодруулга хүсэхэд татгалзахгүй тухай албан бичиг ирүүлэх. 6. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/ 7. Оролцогч байгууллага нь өөрсдийн нийлүүлэх буюу санал болгож буй барааныхаа фото зураг болон техник үзүүлэлт бүхий дэлгэрэнгүй танилцуулга ирүүлэх. 8. Баталгаат хугацаа 1 жил ба баталгаат хугацаанд гарсан үйлдвэрийн гэмтлийг өөрийн зардлаар шуурхай засварлах ажлыг хийж гүйцэтгэхээ баталсан албан бичиг ирүүлнэ. 9. Санал болгож буй барааг санал болгосон хугацаандаа болон үнэдээ багтаан нийлүүлэхийг нотолсон албан бичиг ирүүлнэ. 10. Хэрэв борлуулагч бол Монгол дахь албан ёсны гэрчилгээний хуулбар. /Эх хувиас нь хийсэн хуулбарыг нотариатаар баталгаажуулан, баталгаат орчуулгаар орчуулан баталгаажуулж ирүүлнэ. Тендерийн хүчинтэй байх хугацаанд гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусаагүй байх/ 11. Санал болгосон үнэд тээвэрлэлт, угсралт орсон байх

<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: “Тавантолгой төмөр зам” ХХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Юнион бюлдинг В блок, 11-р давхар. Утас:976+77777727.</p> <p>Тендерийн материалыг 2019 оны 12-р сарын 02-ны өдрийн 14 цаг 00 минутаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: “Тавантолгой төмөр зам” ХХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Юнион бюлдинг В блок, 11-р давхар. Утас:976+77777727.</p> <p>Тендерийн материалыг 2019 оны 12-р сарын 02-ны өдрийн 14 цаг 30 минут-т нээнэ.</p>
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй</p>

Гурав: Техникийн тодорхойлолт

**“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН
ХУРЛЫН ШИРЭЭ, САНДАЛ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**


Нэр төрлийн дугаар	Бараа болон холбогдох үйлчилгээний нэр	Тоо ширхэг	Техникийн тодорхойлолт болон стандарт
Өрөөний зохион байгуулалтын Зураг №1, Зураг №2-т тохирсон байх			
ТТТЗ/201909044 Хурлын ширээ, сандал	Хурлын ширээ /том өрөөнд/	1 ширхэг	<ul style="list-style-type: none">✓ Хэмжээ: Урт 6800-7000мм Өргөн 1800-2000мм Өндөр 750мм✓ 3-аас дээш өнгөний сонголттой байх✓ USB оролттой✓ Микрофоны оролттой байх✓ Орчин үеийн загвартай эдэлгээ сайн даах✓ Кабелийн утасны шийдлийг цэвэрхэн далдалж,✓ Ширээний доор утас бөөгнөрч хөглөрөхгүй✓ Цахилгааны аюулгүй байдлыг хангасан байх✓ Баталгаат хугацаа: 1 жил✓ Зураг №1-тэй тохирсон байх <p>Доорх зурагтай дүйцэхүйц:</p> 

	Хурлын сандал /том өрөө/	40 ширхэг	<ul style="list-style-type: none"> ✓ Гарын тавиуртай, шууг тавихад хөдөлгөөн хязгаарлахгүй ✓ Дугуйгүй ✓ Материал: Даавуу, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, ✓ 100 кг-аас дээш даацтай, ✓ Сайн чанарын, эдэлгээ даахуйц, чанар, хийц, өнгө үзэмжтэй стандарт сандал байна. ✓ Хурлын том ширээтэй хос байх ✓ Баталгаат хугацаа: 1 жил
	Хурлын индэр	1 ширхэг	<ul style="list-style-type: none"> ✓ Модон ✓ Өнгө хурлын том ширээтэй ижил ✓ Өндрийн хэмжээг тохируулдаг байх ✓ Баталгаат хугацаа: 1 жил
	Хурлын өрөөний шүүгээ	1 ширхэг	<ul style="list-style-type: none"> ✓ Хэмжээ: Урт 2000 мм Өргөн 500 мм Өндөр 750 мм ✓ Орчин үеийн загвартай эдэлгээ сайн ✓ Кабелийн утасны шийдлийг цэвэрхэн далдалж, утас бөөгнөрч хөглөрөхгүй байх ✓ Суурин компьютер, А4 хэмжээтэй цаас тавих зайтай, доод тавиур 2 тасалгаатай өсгөгч болон компьютерийн процессор байршуулах боломжтой байх ✓ 2 хаалгатай, дотроо 2-3 тавиуртай ✓ Шүүгээний хаалга цоожтой байх ✓ Өнгө: Хурлын том ширээтэй ижил ✓ Баталгаат хугацаа: 1 жил ✓ Зураг №1 тэй тохирсон байх
	Хурлын ширээ /жижиг өрөө/	1 ширхэг	<ul style="list-style-type: none"> ✓ Хэмжээ: Урт 3600-4000 мм Өргөн 800-1000 мм Өндөр 750мм ✓ 3-аас дээш өнгөний сонголттой байх. ✓ Орчин үеийн загвартай эдэлгээ сайн даах ✓ Сайн чанарын мебель хуулгатай ✓ Баталгаат хугацаа: 1 жил ✓ Зураг №2-т тохирсон байх

	Хурлын сандаг /жигж өрөөнд/	15 ширхэг	<ul style="list-style-type: none"> ✓ Гарын тавиуртай, шууг тавихад хөдөлгөөн хязгаарлахгүй ✓ Материал: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, ✓ 100 кг-аас дээш даацтай, ✓ Сайн чанарын, эдэлгээ даахуйц, чанар, хийц, өнгө үзэмжтэй стандарт сандал байна. ✓ 3-дээш өнгөний сонголттой байх ✓ Баталгаат хугацаа: 1 жил


Зураг №1

ХУРЛЫН ӨРӨӨ-1



Зураг №2

ХУРЛЫН ӨРӨӨ-2



1. **Барааны тодорхойлолт:** Техникийн тодорхойлолтод заасны дагуу
2. **Стандарт:** Тухайн бараа нь стандартыг хангасан байна /нотлох баримтыг хавсаргаж ирүүлнэ/. Мөн гарал үүслийн бичиг ирүүлэх.
3. **Баглаа, боодол:** Бүрэн бүтэн байдлыг хангасан байх.
4. **Бараа хүргэх газар:** “Тавантолгой төмөр зам” ХХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Юнион бюлдинг В блок, 11-р давхар. Утас:976+77777727.
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхой лолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Хурлын ширээ /том/	Техникийн тодорхойлолтод заасны дагуу	1	Ширхэг	“Тавантолгой төмөр зам” ХХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Юнион бүлдинг В блок, 11-р давхар	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 7 хоног	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 30 хоног	
Хурлын ширээ /жигжиг/		1	Ширхэг	“Тавантолгой төмөр зам” ХХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Юнион бүлдинг В блок, 11-р давхар	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 7 хоног	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 30 хоног	

Хурлын сандал	Техникийн тодорхойл олтод заасны дагуу	55	Ширхэг	“Тавантолгой төмөр зам” ХХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Юнион бюлдинг В блок, 11-р давхар	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 7 хоног	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 30 хоног	
Хурлын индэр		1	Ширхэг	“Тавантолгой төмөр зам” ХХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Юнион бюлдинг В блок, 11-р давхар	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 7 хоног	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 30 хоног	
Хурлын өрөөний шүүгээ		1	Ширхэг	“Тавантолгой төмөр зам” ХХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Юнион бюлдинг В блок, 11-р давхар	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 7 хоног	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 30 хоног	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг **[санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу **[тоо]** хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фа кс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

1. **Шалгах болон турших**
 - 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. **Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт**
 - 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. **Оюуны өмчийн эрх**
 - 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. **Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх**
 - 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. **Баталгаат засварын хугацаа**
 - 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа **[тоо]** жил байна.
6. **Гэрээнд өөрчлөлт оруулах**
 - 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. **Төлбөр**
 - 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш **[ГТН-д заасан тоо]** хоногийн дотор шуурхай хийнэ.
8. **Бараа нийлүүлэх хуваарь**
 - 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. **Алданги оногдуулах**
 - 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.

- 10. Үүргээ биелүүлээг үй-гээс гэрээг цуцлах**
- 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх**
- 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[тоо]**¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)²**
- 9.1. Алданги оногдуулах хувь: **[тоо]**
- Алдангийн нийт дүн: **[тоо]**

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ³

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны ___ дугаар сарын ____-наас _____ оны ___ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.